

АЛТАЙН ХЯЗГААР ЛУУ, АНГИЙН ОЙ ЗОРЬСОН АЯН ЗАМЫН ТЭМДЭГЛЭЛ - ДУРСАМЖ

Ц.ГАНБОЛД

*ДХИС-ийн Эрдэм шинжилгээний
хүрээлэнгийн Хилийн аюулгүй
байдал судлалын төвийн ахлах
судлаач, доктор (Ph.D), профессор,
хурандаа*

*Дайчид болгон өөрийн түүхтэй
Дурсамж бүр өвөрмөц өнгөтэй*

Төрөлх Алтайн отрядын 90 жилийн ой болох нь гэсэн зар жилийн өмнөөс илүү их хүчээ аван цуурайтах болж, алба хааж байсан үе үеийн нөхдүүд маань битүүхэн анир чагнан, ямар хувцсаа өмсөх үү?, ямар төмөр хөлгөө сойх уу?, ямар бэлгээ бэлдэх үү? зэргээр бэлтгэлээ базааж буй нь анзаарагдсаар...

Алдаатай оноотой ч алба, амьдрал минь эхэлсэн, 10 гаруй жилийн хугацаат цэргийн албанаас эхлээд хугацаагүй офицерын албаа өнгөрүүлсэн болохоор, дахиад 10 жилийг үзээ ч үү, үгүй юу? гэсэн олон бодол ээлжлэн эргэлдсээр явахыг эргэлтгүй шийдсэн бөлгөө.

Алтайн хязгаар, Аж Богд орно гэдэг бол Д.Болд хурандаагийн хэлсэнчлэн: “Дайрч өнгөрдөг биш, Зорьж очдог”, миний нэмсэн “Драасчилж биш, Золгож мэндэлдэг” нөхдүүдийн газар шүү дээ.

Мэдээж, цаг хугацаа харвасан сум шиг өнгөрч, хүсэн хүлээсэн мөч ойртон, ихэнх нөхдүүд маань 9 дүгээр сарын 6-ны өдрийн өлзийт сайн өдрийг сонгон,

аян замын хол болон бартаатайг тооцон нөөц хугацаатай хөдөлж байгааг “Алтайн отряд-90 жилд, Ахмадууд” сайтаасаа анзааран юу хоцрохов, хөлгийн жолоог Алтайнхаа зүг, Ажийнхаа зүг, Ангийнхаа зүг залав аа.

Ойд зорьсон хилчин нөхдүүд маань Алтай хот-Төгрөг сум-Алтай сум болон Бигэр сум-Цогт сум-Ээж уул-Алтай сум гэсэн хоёр замналаар баг бүлэг, фракцаараа замнаж буй нь цахим мэдээллээс анзаарагдах төдийгүй зам зуур тааралдан, цайлж, хуучилсаар, салъя гэж салсангүй салаа замын эрхээр салан, баг багаараа сонгосон аяны алтан шар замаа хөөн одсон болой.

Хурандаа Д.Болдын түүчээлсэн, миний дагасан бүлэг 6 машинаас бүрдсэн бөгөөд Бигэр сумд хонон, цааш Бигэр болон Цогт сумын хооронд орших Цагаан хаалгын хүрхрээг сонирхон, Цогт сум дээр үдлэн, Ээж ууланд хоноглон цааш Отряд орох “Барбарос” төлөвлөгөөтэй, Баянхонгор, Говь-Алтай аймгийн зааг Бор хоолойн давстай нуураас салан хөдөлсөн болой.

Бигэр сумд нутгийн хүргэн, миний салааны цэрэг, мал эмнэлгийн албаны даргаар ажиллаж байсан хошууч Нямсүрэн маань хадамлаад хүлээж байх ба нутгийн ханагар, Өргөстэйн заставын дарга асан хошууч Мижид мэдээж хүлээж байх учиртай.

Өглөөний бослогын дараа Мижид хошууч ирж, мэндлэн золгосны дараа төрөлх нутгийн брэнд бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг, хүний болон өөрийн нутгийн

хүмүүсийн ганц нүд хужирладаг, амт ааг мэдрүүлдэг “Шимт дээж” дарсны үйлдвэрээр “нутгийн индианууд”-ын хувьд аян замын нөхдүүдээ айлчлуулав, амталгаа хийлгэв.

Үйлдвэрийн захирал Ж.Энхтүвшин биднийг халуун дотно хүлээн авч, үйлдвэрээ танилцуулан, үйлдвэрийн түүхээ хүүрнэн, өнгө алагласан олон төрлийн бүтээгдэхүүнээрээ дайлахын зэрэгцээ аяны уртыг богиносгох арга хэмжээг ч аван бэлэг бичиг болон бужигнуулав.

Талууд сэтгэл хангалуун үлдсэн агаад Цагаан хаалганы хүрхрээ орох аян замаа тэр эрчээрээ шууд эхлүүлсэн авай. Алтан шар зам ивээж, аяны дөрөө сайхан нийлснийх, аз болоход энэ жил бороо хуртайгаас Цагаан хаалганы хүрхрээ маань ус нь элбэг урсах шиг, шуугих шиг л байж, нүд, чих баясгав.

Ахмад жолооч Ч.Алтангэрэл, Б.Нямжав, Майдар нар маань олон жил цэрэг тээврийн тэрэг жолоодон, Чандманийн Зээгтийн уурхайгаас нүүрс тээвэрлэн, УБ-ыг зорин шунгинуулж байсан ч төв замаас 5 км зайд орших энэ газраар дайраагүй, очоогүй байснаа ихэд гайхан бишрэх ажгуу. Энэ нь тэр үеийн цэргийн албан хаагчдын сахилга бат, цаг хугацааны үнэ цэнэ, улсын техник, шатахуунаа зориулалтын дагуу л ашиглаж ирсэн хүмүүжлийг л илэрхийлж, үр хүүхдүүд нь ч аав минь, мэргэжил нэгт найзууд нь амрах зугаалахыг огоорон албаны, амьдралын төлөө нэгэн үзүүрт сэтгэлээр зүтгэж

явсны нь гэрч болсон, амьдралын их сургуулийн нэг ангийг төгссөнтэй тэнцэх ихийг өгүүлэх үйл явдал болсон гэж үнэлж байлаа.

Манай отрядын хүүхдүүд, манай офицер, ахлагч нарын хүүхдүүд тухайлбал, Хурандаа Болдын Энхжаргал, Ахлагч Доржийн Алтанхуяг, Ахлагч Нямжавын Бат-Эрдэнэ, ахлагч агсан Дашцэрэнгийн Уртнасан гээд л зам нийлсэн хүүхдүүд маань ямар сайхан залуус болон өсөж, төлөвшсөн юм бэ, ахмадаа хүндэлж байгаа, бие биетэйгээ харьцаж хандаж байгаа, тусалж дэмжиж байгаа гээд л бахархмаар. Урагшлуулаад тэмдэглэхэд, ахлагч агсан Энх-Амгалангийн маань хүү ахлагч Батчулуун, андуудаа хүлээн авахаар Зуслан булгийн ногоон зүлгэн дээр дүнхийсэн цагаан гэр барьчихсан, алжаал юугий нь тайлж, амрааж асарч тойлж байх юм, хойно ургасан эвэр уртаа гэж... Тэрээр, ахлагчийн дамжаанд сурч байхдаа нагацын хүү Баттүшигийн хамт манайд байснаа дурсан, баярлаж гялайж явдгаа илэрхийлсэн нь бас л нэг “сюрприз” байлаа, цагийн уртад мартсан байжээ. Манайхны гарууд ч чи тэгэх ёстой, ингэх ёстой гэж л лаахайдаж байснаас, та тэгсэн, та ингэсэн гэж дурсдаггүй нь “гайхамшигтай” доо. Алтай зорих аяны алтан шар зам ч хүмүүний чанарыг таниулах бөлгөө.

Мэдээж, хотын жолоочийн ур чадварыг шалгах, говийн хурц ирмэгтэй чулуутай зам ч машины дугуйг цоолох, хагалах биш ёстой л “бөөрийг нь гаргаж” өгч байлаа. Алтай сумдаа амьдран суух

Бургастайн застав, штабын 2 дугаар тасгийн даргаар ажиллаж байсан Мягмаржав хошуучийн маань хүү Өнөржаргал засварын газар ажиллуулан мотортой бүхний хүсэн хүлээдэг засварчин, орон нутагтаа хүлээн зөвшөөрөгдсөн бизнесмен болжээ. Амьтан ах дүүстэй олсон долсноо хуваагаад сурчихсан, “ир, оч, ид, уу” гэсэн сайхан гэр бүл байна. Дүүгийн тусаар л, эвлүүлж өгсөн дугуйгаар нь л хотын, гэрийн бараа харлаа байна.

Ээж уулын байгалийн сайхан, Хаяагийн шийгуаны амттайг гайхсаар Алтайн отрядынхаа замд байх “Замын шанд”-ын заставд замын алжаалыг түр тайлан амсхийв. Хадагтай сүү барин хүндэтгэн угтах хилчдтэйгээ нулимс цийлгэнүүлэн, самсаа нь шархиран золгох нөхдөө харан бахархаж л байлаа.

Ангийн төвийн биеийн тамирын талбайд 30-аад гэр эгнүүлэн барьж, дугаарласан байх агаад гэр дундын зохион байгуулагчид зочдыг угтан байрлуулж байлаа. Ангийн буудал ч хүндтэй зочдоор дүүрэн, хөл хөдөлгөөн ихтэй байлаа.

Олон жил уулзаагүй, бие биеэ өгүүлэн санасан нөхдүүд тал талаас цугларан ёстой л хонь хурга нийлсэн мэт хөл хөдөлгөөн, хөгжилдөөн шуугиан ихтэй мөчүүд үргэлжилсээр... Энд ч уулга алдах, тэнд ч тэврэлдэн үнсэлцэх, тэртээд ч золгох, тэрүүхэндээ хөөрөгдөх, бие биеийнхээ залуужсаныг гайхах, цаашлан явуулах, энэ маань ирсэн үү?, тэр маань хаана явна? хэмээн сураг ажиг тавих, тэр маань байсан

бол хэмээн мэгших гээд л түмэн янзын, бумбан өнгийн уулзалт хязгааргүй мэт үргэлжилж байлаа, тэр мөчүүдэд, тэр өдрүүдэд...

Баярын арга хэмжээний нээлт, ёслолын жагсаал, үзвэр үйлчилгээ, концерт, баярын хурал, шагнал урамшуулал, хүлээн авалт, бэлэг бичиг гардуулах гээд л бүхий л ажиллагаа байж болох хамгийн өндөр түвшинд, бэлтгэл, зохион байгуулалтын дээд түвшинд байлаа. Ой угтсан их ажил хийсэн, бэлтгэлийг сайтар хангасан нь алхам тутамд мэдрэгдэж байсныг хэлэх нь зүйтэй.

Зорьж ирсэн 350-иад, залагдаж ирсэн 50-иад хүнийг сайхан хүлээж аваад, сэтгэл санаа өндөртэйхэн биечлэн үдээд явуулчихна, тэдэнд хүрч ажиллана гэдэг чинь хир баргийн газрын, бас захын аавын хүүгийн амархан хийчих ажил бас биш шүү.

Бакалавр, академийн шавь, дэд хурандаа Э.Майдар маань захирагчийн ажлыг аваад удаагүй ч ой угтсан ихээхэн ажлыг санаачилга, зохион байгуулалт, зангараг заан хийж гүйцээжээ. Хийсэн болгон нь хүн болгонд таалагдах албагүй ч 90 хувийн нь сэтгэл ханамж өндөр байсан гэдэгт огт эргэлзэхгүй байгаа бөгөөд хүн болгонд ганцхан “доллар” л 100% таалагддаг гэж байгаа.

Зочдыг 1988-1992 онуудад отрядын даргаар ажиллаж байсан генерал Я.Пүрэвдорж, захирагч, хурандаа В.Батжаргал нар тэргүүлж, баруун, зүүний магнайг Монгол Улсын хүний гавьяат эмч, төрийн соёрхолт Төмөрбаатар, Монгол Улсын Аж үйлдвэрийн

гавьяат ажилтан Г.Сүхбаатар нар маань манлайлж, Алтайн отрядын анхдагчид хурандаа Д.Болд, С.Энхбаатар гээд л хөвөрч өгөх бөлгөө. Бууриа сахин үлдсэн буурлууд хошууч Нанжид, Балхжав ах, Буяндэлгэр эгч, дээд оны С.Одхүү, С.Зэсэндүйчир анд, С.Сарангэрэл цэрэг гээд л явж өгөхийн зэрэгцээ Алтай сумын мөнхийн залуу гялалзах Өөлд ах, Шалхаан захирал гээд л өнгө чимэг нэмэх...

Мөн Говь-Алтай аймгийн иргэдийн хурлын дарга, зэргэлдээх сумдын засаг дарга нар, Аймгийн шүүхийн ерөнхий шүүгч, шавь Ш.Баттогтох, Хилийн цэргийг төлөөлж хурандаа Д.Амарсанаа, Д.Гуулин баатрын үр хүүхэд, ач зээ нар болох 8 дугаар анги Цогтод хамт төгссөн П.Гандулам, хамт багшилж байсан М.Цогтоо багш нар маань зорин ирсэн байлаа.

Ахмадууд болон ангийн захирагчаар ажиллаж байсан хүмүүс цөөхөн, залуус нь мөн хомсхон, дунд үеийнхэн болох 1977-1990-ээд онуудад ажиллаж байсан хүмүүс л ахиухан иржээ гэж харж байлаа. Тэр үеийн ангийн бие бүрэлдэхүүн бараг бүрэн бүрэлдэхүүнээрээ ирсэн юм шиг санагдсан шүү, нөхдүүд сэтгэгдлээ хуваалцах байх.

Миний хамгийн ихээр уулзахыг хүсч байсан хүн бол хошууч Цахиуртай ах байлаа. Миний дарга байлаа, миний ахын найз байлаа, Москвад дээд курст сурч байхад нь борцтой хоолыг нь мөн ч олон хүртсэнсэн гээд л дурсамж хөвөрнө л дөө. Ахуйн бэртлээс үүдэн ирээгүй ч ойн

дараахан 9 дүгээр сарын 20-диор Баян-Өлгий аймаг руу судалгааны ажлаар явахдаа Ховд хотноо зорьж очин, амар мэндийг нь эрж уулзан баахан ярилцсан.

Зүрх, сэтгэл догдлоож, сэтгэл санаа огшоосон, “байнгын баяр ёслолын байдалтай” байсан халуухан 3 өдөр яах ийхийн зуургүй өнгөрсөн ч 3 жилийн эрч хүчийг олгосон гэж бодож байгаа. Олон сайхан нөхдүүдтэйгээ уулзсан, ярилцсан, богинохон ч гэсэн хамт байсан дурсамжийг, тэр олон нөхдөө нэр, зүсийг дурдан нэгэн тэмдэглэлд багтаах боломжгүй гэдгийг мэргэн уншигчид ойлгож байгаа байхаа.

Гэхдээ ойн үеийн онцлог үйл явдлуудаас дурдах нь зүйтэй байх аа.

Волейболын спортын мастер Г.Нарангэрэл /Нангиа/-ийн нэрэмжит гар бөмбөгийн тэмцээн өрсөлдөөн, оролцогч ихтэй сайхан арга хэмжээ болсон бөгөөд бооцоо, шагналаар ч булах шиг л болов. Э.Лувсанбалдан гуайн хошигнон хэлдэгчлэн “Гай болж, амьд байвал” ангийн 100 жилийн ойгоор энэ удаад санал тавиад амжаагүй “Буудлагын тэмцээн”-ээ зохион байгуулна аа гэж бодож байгаа.

Төрөлх ангийн хамт олон маань сэтгэл, ур ухаанаа шингээсэн, нутаг нугын олон брэндийн цуглуулга болсон гарын бэлэг бэлдэж, ирсэн зочид болгоны гарын алгыг “дээш нь” харуулж байх юм, ёстой гайхамшиг, **б/а**-аадаад баярладаггүй хүн гэж байдаггүй гэж байгаа. Их л хөдөлмөр, их л сэтгэл, мөн их л хүч чармайлт, их л хөрөнгө шингэсэн нь илт юм даа.

Шинэхэн доктор Ц.Эрдэнээгийн маань өлгийдсөн “Алтайн хязгаарын хилчид” ном агуулга, хэвлэлт гээд л бүхний санаанд нийцсэн бүтээл, хамгийн үнэ цэнтэй бэлэг байлаа.

Ангийн ойн концерт гэдэг зүйл журам мэт байх ёстой арга хэмжээ бөгөөд их л цаг зав зарсан, хувцас хунар гээд нүсэр ажил байдаг хэдий ч хамт олны бүтээл гэдгээрээ ихээхэн нүүр тахалдаг, дараагийн ой болтол яригддаг арга хэмжээ байдагсан, одоо ч орчин үедээд, цаг хугацаагаа хэмнээд Хилийн цэргийн чуулгын уран бүтээлчид арыг нь даадаг болсон юм шиг байна. Дангаараа биш юм гэхэд ангийн уран сайханчдыг оролцуулсан хамтарсан концерт бэлдсэн бол ихээхэн таашаах байсан мэт, манайхан ч жаахан уйдсан, залхсан шинжтэй байсан шүү, шударгаар хэлэхэд, Ганболд л бичиж байгаа болохоос биш...

“Муу хүн идсэн, ууснаа” гэдэг ч жаахан хоцрогдсон ойлголт болсон шүү дээ, энэ олон хүний хоол ундыг цаг хугацаанд нь, хүртээмжтэй, амт чанартай зохион байгуулна гэдэг бол төв суурин газраас хол, байгаль цаг уурын хувьд халуун газар ямарч асуудалгүй шийднэ гэдэг ихээхэн чухал ажлыг “вип” хэмжээнд зохион байгуулсан нь ойн арга хэмжээний онцлог асуудал болой. Монгол Улсын мастер тогооч Монхор ах маань өөрийн багийн хамт энэ нүсэр ажлын ард нэр төртэй гарч байна лээ шүү.

Баярын үеийн зочдын үйлчилгээ гэдэг бол бие, сэтгэлийн бяд, хүч шаарддаг төдийгүй

тэрүүхэндээ байнга л их, бага хэл ам дагуулж байдаг чимхлүүр ажилсан, ангийн бүрэлдэхүүн асуудалгүй л шийдэж, хүн болгонд л бараг хүрч, тулж ажиллаж байсныг дурдах нь зүйн хэрэг бөгөөд Арын дарга, шавь, хошууч Энхбаатарын ажлын нэг томоохон үзүүлэлт байлаа.

Үйлчлэх бүрэлдэхүүнд баярлаж талархсанаа илэрхийлэн, хариу хүлээн авалтыг нутгийн анд, Д.Гуулин баатрын ач М.Цогтоо тэргүүтэй хамаатан садангууд нь зохион байгуулж байсан нь нэн шинэлэг, нэн хүнлэг арга хэмжээ байсан шүү.

Мань мэт ч юун баярлах, талархах, өгсөн болгоныг нь туушиндаад л, туугаад л байсан санагдана, ичиж үхмээр...Манайхан бие биедээ хэлэлгүй, Цагаан булаг руу булагнаад л, булгаад л байх шиг байсан шүү, тэнд юу байдаг, яадаг юм болоо?

Баярын арга хэмжээний зай завсраар сумын төвөөр жаахан хэсүүчилж, Цагаан булгийнхаа рашаанаас амсан таашааж, залуу насны дурсамжаа сэдрээн амрахуй, “тэрүүхэн хооронд, шаал дэмий, жаал юм бодчихсон байна лээ” гэвэл мөн алав аа...

Гэр бүл маань ажиллаж байсан сумын сургуульд өөрийн бүтээлийн дээжис, сурганы чиглэлийн номууд, сумын болон отрядын цэцэрлэгт том охин, Монтессори арга зүйч Г.Мөнхцэцэгийн туурвисан “Монтессори арга зүй”-н цуврал номуудаас бэлэглэсэнээ захирал Ц.Наранцацралтад гардуулан өгч, бага сага ажил амжуулав.

“Орсон бороо арилж, ирсэн гийчид буцдаг” жам ёсоор сум, отрядын өмнө ба хойно орших угталт, үдэлтийн хаалган дээрээс явах явах чиглэлдээ ангийн хамт олноор үдүүлэн буцах аяндаа шуударсан агаад нуурандаа хоргодох намрын шувууд шиг үдэж буй, үлдэж буй анд нөхдүүдээсээ салж ядан, сэтгэл, зүрх нэг л хоргодонгуй, нэг л нялхархуу байсныг үгээр хэлж, үзгээр бичих аргагүй байсан болой.

“100 жил хүртэл 10 жил ёстой нэг новширно доо” гэсэн өөдрөг бодол тээн буцах аяндаа мордсонсон, бид бүгд...

Зуун жилээр зургаадугаар отряддоо эргэн уулзах ерөөлийг талбия.

Төгсгөлд: Ангийн удирдлагад хамтран ажиллах талаар тавих горимын гэдэг ч юм уу?, бас жаахан далиудуу хоёр санал байгаа юм.

Нэгэн зүйл: Бид баяр угтсан болон баярын үеэр жаал сайхан ажил зохион байгуулдаг бөгөөд баяраа дуусгаад л санаа амарч бүхнийг орхидог, мартдаг гэмтэй.

Энэ үеийн арга хэмжээ, үйл явдлуудыг баримтжуулах, эргэн сурталчлах, хүргэх ажлууд нь хоцордог, дараагийн ой болтол

орхигддог. Баярын үеийн үйл явдлыг эргэн сурталчлах, сэргээх зорилгоор “Хил судлал” сэтгүүлийн ээлжит дугаарыг ойн дугаар болгон гаргахад хамтран ажиллая гэсэн санал тавьж байгаа юм. Сулинхээрийн отряд яг энэ байдлаар ажиллаж, ойн дугаараа гаргаж хүргэсэн нь олны таашаал хүлээсэн ажил болж байсан. Тухайн үеийн ангийн орлогч, дэд хурандаа Даваатогтох энэ талаар арвин туршлага хуримтлуулсан болой.

Нэгэн зүйл: Ангийн ойд зориулан зохион байгуулсан шүлгийн уралдаанд түрүүлсэндээ баярлаж талархаж байгаач шүлэгт ая оруулах тал дээр хамтран ажиллаж, аятайхан дуу болгоё гэсэн санал тавьж байгаа юм. Яаруу, сандруу хийлгэсэн ая маань нэг л сайн болоогүй мэт.

Аян замын тэмдэглэлийг тэрлэсэн: Алтайн отрядын 1978 /2 дохь он/ оны хугацаат цэргийн албаны хилчин-байлдагч, бага түрүүч, 1984 онд Москва хотноо ХЦКД сургуулиа төгсөн төрөлх отряддоо эргэн ирж ажилласан отрядын анхны унаган офицер, доктор, профессор, хурандаа Цагааны Ганболд.

2023-10-7-ны өлзийтэй сайн өдөр тэрэлж дуусгав.

